



ТӨРИЙН ӨМЧИЙН 6 ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛУУДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/184, А/230, А/02
А/170, А/161, А/211

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол улсын Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.11 дахь заалт, 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн “Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн 2.4.1, 2.4.7 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Суралцагч бусад их сургуулиас хичээл судлах үйл ажиллагааг зохицуулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг “Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичиг”-т хамаарах сургуулиуд санамж бичгийн хэрэгжих хугацаанд мөрдөн ажилласугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Монгол улсын Их сургуулийн Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Д.Бадмаанямбуу/, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал /Х.Энхжаргал/, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Боловсрол хариуцсан дэд захирал /Г.Батбаатар/, Монгол улсын Боловсролын их сургуулийн сургалт эрхэлсэн дэд захирал /Х.Тамир/, Соёл урлагийн их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал /Д.Одсүрэн/, Хөдөө аж ахуйн их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал /Р.Чанцалдулам/ нарт үүрэг болгосугай.

АШУУИС-ИЙН ЗАХИРАЛ

Н.ХҮРЭЛБААТАР

МУИС-ИЙН ЗАХИРАЛ

Б.ОЧИРХУЯГ

ХААИС-ИЙН ЗАХИРАЛ

Т.ХЭРҮҮГА

МУБИС-ИЙН ЗАХИРАЛ

О.АЛТАНГОО

ШУТИС-ИЙН ЗАХИРАЛ

Б.ОЧИРБАТ

СУИС-ИЙН ЗАХИРАЛ

Э.СОНИНТОГОС



2021 оны 09 дугаар сарын 16-ны өдрийн
1184, 1180, 1182 дугаар хамтарсан тушаалын хавсралт
1170, 1169, 1161

1117144746

UNIVERSITY OF
SCIENCE AND
TECHNOLOGY
11171 9087087

**СУРАЛЦАГЧ БУСАД ИХ СУРГУУЛИАС ХИЧЭЭЛ СУДЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Суралцагч нь өөрийн суралцаж буй сургуулиас гадна төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичигт дурдагдсан бусад их сургууль (цаашид “их сургууль” гэнэ)-иас тодорхой түвшний суралцахуйн үр дүнг эзэмших зорилгоор хичээл сонгон судлах нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2. Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичигт дурдагдсан сургуулиуд энэхүү журмыг мөрдөнө.

2. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Их сургууль: Төрийн өмчийн их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичигт дурдагдсан сургуулиуд;

2.2. Их сургууль хооронд хичээл сонгон судлах: Нэг их сургуулийн суралцагч өөр их сургуулийн хичээлээс сонгон суралцах үйл ажиллагаа;

2.3. Илгээгч их сургууль: Суралцагчийн үндсэн харьяаллын сургууль;

2.4. Хүлээн авагч их сургууль: Суралцагчийн сонгон судлах хичээлийн харьяа сургууль;

2.5. Хичээл солилцооны систем: Суралцагч судлах хичээлийн санал гаргах, илгээгч болон хүлээн авагч их сургуулиудын зөвшөөрлийг бүртгэх, хичээл солилцоотой холбоотой журам, зарлал, мэдээллийг түгээх цахим систем;

3. ИХ СУРГУУЛЬ ХООРОНД ХИЧЭЭЛ СОНГОН СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Суралцагч нь дараах зорилгоор өөр сургуулиас хичээл сонгон судалж болно.

3.1.1. Өөрийн хөтөлбөрт туссан тодорхой хичээлийг дүйцүүлэх (цаашид “дүйцүүлэх” гэнэ);

3.1.2. Өөрийн хөтөлбөрийн чөлөөт сонголтын эсвэл бусад нэгжээс судлуулахаар тодорхойлогдон тодорхой хичээлийн нэр заагаагүй багцын биелэлтэд тооцуулах (цаашид “багцад тооцуулах” гэнэ);

3.1.3. Өөрийн хөтөлбөрийн биелэлтэд тооцуулахгүй ч өөрийн мэдлэг, чадвараа нэмэгдүүлэх (цаашид “нэмэлтээр судлах”);

3.2. Дүйцүүлэх зорилгоор өөр сургуулиас хичээл сонгон судлах тохиолдолд “Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг дүгнэх, дүйцүүлэхэд баримтлах үлгэрчилсэн журам”-д туссан дүйцүүлэх хичээлд тавигдах шаардлагыг хангасан байна. Уг шаардлагыг хангасан буюу дүйцүүлж болох тухай дүгнэлтийг харьяалах нэгжийн тэнхим тодорхойлно.

3.3. Багцад тооцуулах зорилгоор өөр их сургуулийн ижил түвшний хөтөлбөрийн хичээл солилцооны системд бүртгэлтэй хичээлээс сонгон судлах боломжтой. Ахисан түвшний суралцагч нь удирдагч багш, харьяалах тэнхимийн зөвшөөрлөөр доод түвшний хичээлээс сонгон судалж болно.

3.4. Суралцагч өөрийн сонирхлоор бусад их сургуулиас нэмэлтээр хичээл сонгон судлах тохиолдолд уг хичээлийг өөрийн хөтөлбөрийн багцын биелэлтэд тооцохгүй. Амжилттай судалсан хичээлийг төгсөлтийн албан ёсны баримт бичигт тэмдэглүүлж болно.

3.5. Судлах хичээл нь өмнөх залгамж холбоотой бол залгамж холбооны хичээлийг амжилттай судалсан, эсвэл дүйцүүлсэн байна.

3.6. Суралцагч нь хаврын улиралд өөр сургуульд судлах хичээлийн саналаа 11 дүгээр сарын эхний долоо хоногт, намрын улиралд судлах хичээлийн саналаа 3 дугаар сарын сүүлийн долоо хоногт хичээл солилцооны системээр урьдчилан гаргана. Суралцагч нэг улиралд 3 хүртэлх хичээлд санал өгч болно.

3.7. Суралцагчийн гаргасан саналыг илгээгч болон хүлээн авагч их сургуулиуд зөвшөөрснөөр хүлээн авагч их сургуульд хичээл судлах эрх нээгдэнэ.

3.7.1. Илгээгч их сургуулийн харьяалах нэгж нь өөрийн суралцагчдын өөр их сургуульд судлахаар гаргасан саналыг хэлэлцэж тухайн хичээлийг судалж болох тухай дүгнэлт гаргана. Дүгнэлтийг суралцагчдын санал өгсний дараагийн долоо хоногт багтаан хичээл солилцооны системд бүртгэнэ.

3.7.2. Хүлээн авагч их сургууль нь илгээгч их сургуулиас зөвшөөрсөн суралцагчийн саналыг өөрийн сургуульд хүлээн авах боломжтой эсэх талаар илгээгч их сургуулийн дүгнэлт гарсны дараагийн долоо хоногт багтаан шийдвэрлэж, хичээл солилцооны системд баталгаажуулна.

3.8. Илгээгч болон хүлээн авагч сургуулиудын дүгнэлтээр зөвшөөрөгдсөн суралцагчийн өөр сургуульд судлах хичээлийн мэдээллийг өөрийн сургалтын системд үүсгэн сонгуулж, өөрийн сургуулийн багц цагийн үнэлгээгээр сургалтын төлбөрийг төлүүлсэн байна. Зарим мэргэжлийн хичээлийн онцлогоос шалтгаалсан нэмэлт төлбөрийг хүлээн авагч сургууль нэмэлтээр төлүүлж болно.

3.9. Хүлээн авагч их сургууль нь өөр сургуулиас хичээл судлахаар зөвшөөрөгдсөн суралцагчийн тоо болон өөрийн сургуулийн суралцагчдын тооноос хамааруулсан хичээлийн хуваарь хийнэ.

3.10. Хүлээн авагч их сургууль нь хичээл судлахаар зөвшөөрөгдсөн өөр сургуулийн суралцагчдыг өөрийн сургалтын системд үндсэн бус суралцагчаар бүртгэж, сургалтын системд нэвтрэх боломжийг хангана.

3.11. Хичээлийн хуваарь тавигдсаны дараа хүлээн авагч их сургуулийн хичээл баталгаажуулах хугацаанд тухайн суралцагч сургалтын мэдээллийн системд нэвтэрч судлах хичээлээ баталгаажуулна.

3.12. Илгээгч их сургуулийн суралцагч нь хүлээн авагч их сургуулийн суралцагчидтай нэгэн адилаар хичээл судалж, дүгнүүлнэ.

3.13. Судалсан хичээлийн үнэлгээ хүлээн авагч талын системд орсны дараа судалсан хичээл, дүнгийн мэдээллийг суралцагч бүрээр илгээгч их сургуульд хүргүүлнэ.

3.14. Хүлээн авагч их сургуулиас ирүүлсэн дүнг илгээгч тал өөрийн сургалтын мэдээллийн системд оруулна.

3.15. Суралцагч сургалтын явцад хичээл цуцлах тухай хүсэлт гаргавал хүлээн авагч их сургуулийн журмын хүрээнд шийдвэрлэнэ.

3.16. Багцад тооцуулах зорилгоор буюу өөрийн хөтөлбөрт хичээлийн нэр тодорхойгүй тохиолдолд хүлээн авагч их сургуулийн хичээлийн нэр, багц цагийн хэмжээгээр тооцно.

3.17. Суралцагч нь хичээл судлах явцад хүлээн авагч их сургуулийн сургалтын үйл ажиллагаатай холбогдох дүрэм, журам, хэм хэмжээг баримтална.

3.18. Хүлээн авагч их сургууль нь илгээгч их сургуульд дүнгийн мэдээллийг илгээсний дараа илгээгч талын суралцагчдын мэдээллийг хадгалах шаардлагагүй.

4. ИХ СУРГУУЛЬ ХООРОНДЫН ТӨЛБӨРИЙН ТООЦОО

4.1. Илгээгч их сургууль нь хүлээн авагч их сургуулийн хичээлийн багц цагийн хэмжээнээс хамаарах төлбөрийг сонгосон суралцагчийн тоогоор улирлын төгсгөлд хүлээн авагч талд шилжүүлнэ.

4.2. Төлбөрийн хувь хэмжээг сургалтын үйл ажиллагааны зардалд үндэслэн их сургуулиуд жил бүр шинэчлэн тогтооно.

5. БУСАД

5.1. Их сургуулиуд хичээлийн мэдээллийг суралцагчдад ил тод, нээлттэй хүргэнэ.

5.2. Суралцагч нь суралцах хугацаандаа бакалаврын түвшинд 15, ахисан түвшинд 6 хүртэлх багц цагийн хичээлийг дүйцүүлэх болон багцад тооцуулах зорилгоор өөр сургуулиас сонгон судалж болно. Нэмэлтээр судлах хичээл нь энэхүү хязгаарлалтад хамаарахгүй.

5.3. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал их сургуулиудын хамтарсан ажлын хэсэг шийдвэрлэнэ.
